

## “МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны ~~04~~ сарын 14 өдөр

№ 01

Улаанбаатар хот

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт, хэтийн төлөвийг харгалзан нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосугай.
2. Дээрх ногдол ашгийг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бэлнээр өөрийн компаниар дамжуулан олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Будрагчаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЧИНЗОРИГ

4

**“МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 11 өдөр

№ 08

Улаанбаатар хот

**КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ**

“Махимпэкс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн  
ТОГТООХ НЬ:

1. “Махимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

|                      |                |                                |
|----------------------|----------------|--------------------------------|
| Комиссын дарга       | Ц.Энхцогт      | /Ерөнхий менежер/              |
| Нарийн бичгийн дарга | И.Өлзийбаяр    |                                |
| Гишүүд:              | Н.Алтан-Эрдэнэ | /Хүний нөөцийн менежер/        |
|                      | Т.Болортуяа    | /Борлуулалтын албаны дарга/    |
|                      | Н.Одгэрэл      | /МБҮ-ийн дарга/                |
|                      | И.Галтхүү      | /Тооцооны нягтлан бодогч/      |
|                      | Г.Ананд        | /Хуулийн зөвлөх/               |
|                      | Л.Болормаа     | /Маркетингийн менежер/         |
|                      | Ц.Хулан        | /ХКҮ-ийн нягтлан бодогч/       |
|                      | Б.Номин-Эрдэнэ | /ХКҮ-ийн нягтлан бодогч/       |
|                      | Н.Золзаяа      | /ХКҮ-ийн нягтлан бодогч/       |
|                      | Адъяа          | /ХКҮ-ийн маркетингийн менежер/ |

2. Компанийн Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссын дарга /Ц.Энхцогт/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ЧИНЗОРИГ



## “МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

№ 03

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 60 дугаар зүйлийн 1 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Махимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хотод компанийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай.  
Үүнд:
  1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
  2. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
  3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг батлах
  5. Ногдол ашиг хувиарлах тухай
  6. Бусад
3. Хувьцаа эзэмшигчдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хурал хуралдуулах тухай зарыг 2-оос доошгүй удаа мэдээлэх, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2013 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдэд танилцуулах хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЧИНЗОРИГ

## “МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 04 сарын 11 өдөр

№ 04

Улаанбаатар хот

### ТООЛЛОГЫН КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Махимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

|                 |                |                             |         |         |
|-----------------|----------------|-----------------------------|---------|---------|
| Комиссын дарга: | Т.Болортуяа    | /Борлуулалтын Албаны дарга/ |         |         |
| Гишүүд:         | И.Галтхүү      | /Тооцооны                   | нягтлан | бодогч/ |
|                 | Б.Номин-Эрдэнэ | /ХКҮ-ийн                    | нягтлан | бодогч/ |
|                 | Ц.Хулан        | /ХКҮ-ийн                    | нягтлан | бодогч/ |
|                 | Д.Амарбат      | /Нягтлан бодогч/            |         |         |

2. Хурлын саналыг тоолж, санал хураалтын дүнг үнэн зөв нэгтгэж хуралд танилцуулахыг комиссын дарга /Т.Болортуяа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЧИНЗОРИГ